

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2010...оны...дугаар

Улаанбаатар

сарын ... ны ... өдөр

хот

### БЭЛЧЭЭРИЙН ТУХАЙ

#### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

##### Нийтлэг үндэслэл

#### 1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь бэлчээрийг ашиглах, хамгаалах, сайжруулах, эзэмшихтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

#### 2 дугаар зүйл. Бэлчээрийн тухай хууль тогтоомж

2.1. Бэлчээрийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Газрын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, Газрын төлбөрийн тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

#### 3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1. “Бэлчээр” гэж мал амьтан **идээшлэх боломжтой** ургамлын нөмрөг бүхий газрыг;

3.1.2. “Отрын бэлчээр” гэж ган, зуд зэрэг байгаль цаг уурын нөхцөл хүндэрсэн үед ашиглах зорилгоор холбогдох шатны төрийн захиргааны байгууллагаас тусгайлан хил тогтоосон нөөц бэлчээрийг;

3.1.3. “Дамжин өнгөрөх бэлчээр” гэж мал туувар болон нүүдэл хийх зориулалтаар холбогдох шатны төрийн захиргааны байгууллагаас хил тогтоосон зурвас бэлчээрийг;

3.1.4 “Хадлангийн талбай” гэж Газрын тухай хуулиар газрын нэгдмэл санд бүртгэгдсэн хадлангийн газар болон холбогдох шатны төрийн захиргааны байгууллагаас зөвшөөрсөн өвс бэлтгэж болох ургац бүхий бэлчээрийн хэсгийг;

3.1.5. “Бэлчээрийн даац” гэж тухайн бэлчээрт сөрөг нөлөө учруулахгүйгээр тодорхой хугацаанд бэлчээж болох мал, амьтны тоогоор илэрхийлэгдэх бэлчээрийн нэгж талбайн чадамжийг;

3.1.6. “Бэлчээрийн нэгж талбар” гэж тодорхой хил, заагтай, эзэмшилт, ашиглалтын зориулалт нь ижил, кадастрт тусгагдсан, оноосон дугаартай бэлчээрийн хэсгийг;

3.1.7. “Бэлчээр зохион байгуулалтын төлөвлөгөө” гэж бэлчээрийг нөөц болон даац, бүс нутгийн онцлог, бэлчээр ашиглаж ирсэн уламжлалыг харгалзан иргэн, малчдын бүлэг, аж ахуйн нэгж, байгууллагад ашиглуулах, хамгаалах, эзэмшүүлэх, нөхөн сэргээх, сайжруулах бодлогыг тусгасан газар зохион байгуулалтын баримт бичгийн бүрэлдэхүүн хэсгийг;

3.1.8. “Малчин өрх” гэж Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 4.1.2-т заасныг;

3.1.9. “Малчдын бүлэг” гэж бэлчээрийн мал аж ахуй эрхлэх зорилгоор бэлчээрийн нэгж талбарт жилийн нэг буюу хэд хэдэн улиралд нутаглаж, бэлчээрийг хамтран ашиглах, эзэмших гэрээтэй, Иргэний хуулийн 481.1-д заасны дагуу зохион байгуулагдсан 10-аас цөөнгүй /говийн бүсэд 5-аас цөөнгүй/ малчин өрхийг;

**3.1.10.** “Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч” гэж арвин ашиг шимт үүлдэр, хэвшлийн мал, тэжээвэр амьтныг суурин болон хагас суурин байдлаар технологийн дагуу маллан үйлдвэрлэл эрхэлж, бүтээгдэхүүнээ төвлөрсөн хэрэгцээнд нийлүүлдэг иргэн, хуулийн этгээдийг;

3.1.11. “Бэлчээрийг эзэмшигч” гэж энэ хуулийн 3.1.9, 3.1.10-т заасныг;

3.1.12. “Бэлчээр ашиглагч” гэж энэ хуульд заасан зориулалтын дагуу бэлчээр ашиглаж буй иргэн, хуулийн этгээдийг;

3.1.13. “Таримал бэлчээр” гэж мал бэлчээх, хадлан, тэжээл бэлтгэх зориулалтаар нэг ба олон наст ургамал тарьж ургуулсан газрыг;

3.1.14. “Сайжруулсан бэлчээр” гэж бэлчээрийн ургамлын зүйлийн бүрэлдэхүүн, ургацыг нэмэгдүүлэх зорилгоор услах, бордох, хамгаалах, нөхөн сэргээх зэргээр тордсон бэлчээрийг;

3.1.15. “Доройтсон бэлчээр” гэж ургамлын зүйлийн бүрэлдэхүүн сүүлийн үнэлгээ хийснээс хойш хугацаанд өөрчлөгдөж, цөөрч, ургац буурч мал, амьтан бэлчээх нөөц багассан нь эрх бүхий мэргэжлийн байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон бэлчээрийг.

#### **4 дүгээр зүйл. Төрөөс бэлчээрийн талаар баримтлах зарчим**

4.1. Төрөөс бэлчээрийн талаар дараахь зарчмыг баримтлана:

4.1.1. бэлчээр нь эзэмшүүлсэн эсэхээс үл хамааран төрийн хяналтад байх;

4.1.2. бэлчээрийг даацад нь нийцүүлэн өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржаа, отрын нөөц нутаг, эрчимжсэн аж ахуйн бүс гэсэн ерөнхий хуваарийн дагуу төлөвлөж ашиглах;

4.1.3. бэлчээрийг малчдын бүлэг, эрчимжсэн аж ахуй эрхлэгчдэд зөвхөн мал аж ахуй эрхлэх зориулалтаар эзэмшүүлэх.

#### **5 дугаар зүйл. Бэлчээр ашиглалтын ангилал**

5.1. Бэлчээрийг ашиглалтын зориулалтаар нь дараахь байдлаар ангилна:

5.1.1. Нийтээр ашиглах бэлчээр:

5.1.2. Эзэмшлийн бэлчээр;

## **6 дугаар зүйл. Бэлчээрийн хилийн зааг тогтоох**

6.1. Аймаг дундын отрын бэлчээрийн хилийн заагийг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийг үндэслэн Засгийн газар, сум дундын отрын бэлчээрийн хилийн заагийг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийг үндэслэн аймгийн Засаг дарга, сумын отрын бэлчээрийн хилийн заагийг сумын Засаг дарга;

6.2. Хэд хэдэн аймгийн нутгийг дамжин өнгөрөх мал тууврын замын хилийн заагийг Засгийн газар, отор нүүдэл хийх болон орон нутгийн чанартай мал тууврын дамжин өнгөрөх замын хилийн заагийг тухайн шатны Засаг дарга;

6.3. Бэлчээрийн мал аж ахуй эрхлэх зориулалтаар малчдын бүлэгт батлагдсан төлөвлөгөөний дагуу эзэмшүүлэх бэлчээрийн байршлыг баг, хорооны Иргэдийн Нийтийн Хурлын саналыг харгалзан сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал;

6.4. Эрчимжсэн мал аж ахуй эрхлэх бүс нутгийн хилийн заагийг байгаль газар зүйн нөхцөл, зах зээлийн байршил зэргийг харгалзан аймаг, нийслэл, сумын Засаг дарга тус тус тогтооно.

## **7 дугаар зүйл. Эзэмшүүлэх бэлчээрийн хэмжээ, хугацаа**

7.1. Малчдын бүлэгт эзэмшүүлэх бэлчээрийн хэмжээг малын төрөл, тоо, бэлчээр зохион байгуулалтын төлөвлөгөө болон баг, хорооны Иргэдийн Нийтийн Хурлын саналыг үндэслэн сумын Засаг дарга;

7.2. Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд эзэмшүүлэх бэлчээрийн хэмжээг малын төрөл, тоо, бизнес төлөвлөгөөг үндэслэн баг, хорооны Иргэдийн Нийтийн Хурлын саналыг үндэслэн сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно.

7.3. Бэлчээрийг малчдын бүлэг, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд 15 жилийн хугацаагаар эзэмшүүлнэ. Бэлчээр эзэмших эрхийн гэрчилгээг сунгах хугацаа нэг удаад 15 жилээс илүүгүй байна.

7.4. Бэлчээрийг эзэмшүүлэх асуудлыг Газрын тухай хуулийн 21.4.3, 21.5.3-т заасны дагуу сум, дүүргийн Засаг дарга хүсэлтийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор шийдвэрлэнэ.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ**

### **БЭЛЧЭЭРИЙН ХАРИЛЦААНЫ ТАЛААРХИ ТӨРИЙН , НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ БОЛОН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН БҮРЭН ЭРХ**

**8 дугаар зүйл.** Бэлчээрийн харилцааны талаархи төрийн байгууллагын бүрэн эрх

**8.1. Улсын Их Хурал нь бэлчээрийн талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:**

8.1.1. бэлчээрийг ашиглах, хамгаалах, эзэмших, сайжруулах талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлох;

**8.2. Засгийн газар бэлчээрийн талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:**

8.2.1. бэлчээрийн талаар төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах;

8.2.2. бэлчээрийг ашиглуулах, эзэмшүүлэхтэй холбогдсон нийтлэг заавар, дүрэм, журам, хөтөлбөр болон бусад эрх зүйн актуудыг баталж мөрдүүлэх;

8.2.3. газрын болон хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тавьсан саналыг үндэслэн бэлчээрийн зориулалтыг өөрчилж өөр ангиллын газарт шилжүүлэх, өөр ангиллын газрыг бэлчээрт шилжүүлэх асуудлыг шийдвэрлэх.

**8.3. Бэлчээрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:**

8.3.1. Бэлчээрийн талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах;

8.3.2. Бэлчээрийг хамгаалах, сайжруулах, бэлчээрийн даацад үнэлгээ хийхтэй холбогдсон аргачлал, заавар, дүрэм, журмыг баталж, хэрэгжилтэд хяналт тавих;

8.3.3. Бэлчээрийн нөөц, ашиглалт, хамгаалалт, чанарын мэдээллийн санг Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай хамтран бүрдүүлж шаардлагатай арга хэмжээг зохион байгуулах;

8.3.4. Малчдын бүлэг болон эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид бэлчээр эзэмшүүлэх гэрээний загварыг батлах;

8.3.5. Энэ хуулийн 3.1.9-т заасан малчдын бүлэгт олгох гэрчилгээний загварыг батлах.

**8.4. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь бэлчээрийн талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:**

8.4.1. Бэлчээрийн доройтлын үнэлгээ хийх аргачлалыг холбогдох байгууллагатай хамтран баталж, мөрдүүлэх;

8.4.2. Бэлчээрийн төлөв байдлын зураглал, цаг уурын өөрчлөлтийн мэдээллээр хэрэглэгчдийг хангах;

**8.5. Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь бэлчээрийн талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:**

8.5.1. Бэлчээрийн бүртгэл, тайланг хууль тогтоомжийн дагуу газрын нэгдсэн бүртгэл тайланд тусгах;

8.5.2. Бэлчээрийн ангилал, ашиглалтын зураглал, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх;

8.5.3. Төрийн болон бусад холбогдох байгууллагуудыг шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах.

#### **8.6. Аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь бэлчээрийн талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:**

8.6.1. Тухайн жилийн бэлчээр зохион байгуулалтын төлөвлөгөөг батлах, биелэлтэд хяналт тавих, тайланг хэлэлцэж, дүгнэлт, шийдвэр гаргах;

8.6.2. Энэ хуулийн 8.2.2-т заасан нийтлэг дүрэм, журамд нийцүүлэн тухайн орон нутгийн онцлогт тохирсон дүрэм, журмыг батлах;

8.6.3. Бэлчээрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн эрчимсэн мал аж ахуй эрхлэх бүс нутгийг тогтоох.

#### **8.7. Сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь бэлчээрийн талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:**

8.7.1. Сумын тухайн жилийн бэлчээр зохион байгуулалтын төлөвлөгөөг батлах, биелэлтэд хяналт тавих, тайланг хэлэлцэж, дүгнэлт, шийдвэр гаргах;

8.7.2. Энэ хуулийн 8.9.5-т заасны дагуу бэлчээрийн ургац, даац хэтэрсэн тохиолдолд уг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх.

#### **8.8. Аймаг, нийслэлийн Засаг дарга нь бэлчээрийн талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:**

8.8.1. Сум, дүүргийн Засаг даргын бэлчээрийн талаар гаргасан шийдвэртэй холбогдох гомдол, маргааныг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх.

#### **8.9. Сум, дүүргийн Засаг дарга нь бэлчээрийн талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:**

8.9.1. Энэ хуулийн 3.1.19-т заасан малчдын бүлгийг бүртгэж, гэрчилгээ олгох, мэдээллийн сан бүрдүүлэх;

8.9.2. Бэлчээрийг эзэмшүүлэх шийдвэр гаргах, гэрчилгээ олгох, гэрээ байгуулж хэрэгжилтэнд хяналт тавих;

8.9.3. Тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд Газрын тухай хуулийн 58.2-т заасан газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар 5 жилд нэг удаа хийлгүүлж гаргасан дүгнэлтэд үндэслэн доройтсон бэлчээрийг нөхөн сэргээх, хамгаалах арга хэмжээг зохион байгуулах;

8.9.4. Бэлчээр ашиглалтын тухайн жилийн төлөвлөгөөг баг, хорооны Иргэдийн Нийтийн Хурлын саналыг харгалзан боловсруулж Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн батлуулж хэрэгжилтийг зохион байгуулах;

8.9.5. Энэ хуулийн 7.3.2-т заасан аргачлалын дагуу тухайн бүс нутгийн бэлчээрийн ургац, даацыг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран жил бүр тогтоож, бэлчээрийн ургац, даац хэтэрсэн тохиолдолд уг асуудлыг Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оруулж шийдвэрлүүлэх;

8.9.6. Тухайн жилийн байгаль, цаг уурын нөхцлөөс хамаарч бэлчээрийг малаас чөлөөлөх хугацааг тогтоож хэрэгжилтийг зохион байгуулах.

8.9.7. Сум дүүргийн Засаг даргын дэргэд тухайн нутаг дэвсгэрийн бэлчээрийн ашиглалт, хамгаалалтын талаар зөвлөмж гаргах эрх бүхий холбогдох мэргэжилтнүүд, төрийн бус байгууллага болон бэлчээр ашиглагчийн төлөөллөөс бүрдсэн орон тооны бус зөвлөл байж болно.

**8.10. Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал нь бэлчээрийн талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:**

8.10.1. Малчдын бүлэг байгуулах, бэлчээрийг гэрээгээр эзэмших хүсэлтийг хүлээн авч хэлэлцэн санал дүгнэлт гаргаж сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх;

8.10.2. Бэлчээр ашиглагч, эзэмшигчээс бэлчээр ашиглалтын талаар гаргасан саналыг хэлэлцэн дээд шатны хуралд уламжлах;

8.10.3. Бэлчээрийг ашиглах, хамгаалах, сайжруулах талаар Засаг даргын зохион байгуулсан ажлын тайланг хэлэлцэж дүгнэлт гаргах.

**8.11. Баг, хорооны Засаг дарга нь бэлчээрийн талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:**

8.11.1. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, дээд шатны Засаг даргын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах;

8.11.2. Бэлчээрийн тухай хууль тогтоомж, бэлчээрийг ашиглах, эзэмших, хамгаалах талаархи нийтлэг шаардлагын биелэлтийг хангуулах;

8.11.3. Тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд бэлчээрийн эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагыг хангуулах;

8.11.4. Бэлчээр ашиглагч, эзэмшигчийн оролцоотойгоор доройтсон бэлчээрт нэг ба олон наст ургамал тариалах, бэлчээрийг сайжруулах боломжийг нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулах.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ**

### **БЭЛЧЭЭР АШИГЛУУЛАХ, ЭЗЭМШҮҮЛЭХ**

#### **9 дүгээр зүйл. Бэлчээрийг ашиглуулах, эзэмшүүлэх**

9.1. Бэлчээрийг тухайн нутгийн онцлог, мал аж ахуй эрхлэх уламжлал, зохистой ашиглах, хамгаалах, сайжруулах шаардлагыг харгалзан өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржаа гэсэн ерөнхий хуваарийн дагуу ашиглана.

9.2. Зуслан, намаржаа, отрын болон дамжин өнгөрөх бэлчээрийг нийтээр ашиглана.

9.3. Байгалийн тогтоцоор буй болсон гол горхи, нуур цөөрөм, хужир мараа бүхий бэлчээрийг нийтээр ашиглана.

9.4. Өвөлжөө, хаваржааны бэлчээрийг малчдын бүлэгт, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд улирал харгалзахгүйгээр тодорхой хугацаа, нөхцөл, гэрээний дагуу эзэмшүүлж болно. Гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд, гадаадын **болон харъяалалгүй** иргэнд энэ заалт хамаарахгүй.

9.5. Нийт бэлчээрийн 10-аас багагүй хувийг аймаг, сум дундын болон сумын отрын бэлчээр болгон хамгаалалтанд авч байгаль, цаг уур хүндэрсэн үед ашиглана.

9.6. Аймаг дундын отрын бэлчээрт мал оруулахыг бэлчээрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага байгаль, цаг уурын нөхцөл байдлыг харгалзан холбогдох аймгийн Засаг дарга нартай зөвшилцөн шийдвэрлэнэ.

9.7. Сум дундын отрын бүс нутгийн бэлчээрт мал оруулахыг аймгийн Засаг дарга, сумын отрын бүс нутгийн бэлчээрт мал оруулахыг сумын Засаг дарга, байгаль, цаг уурын нөхцөл байдлыг харгалзан тус тус шийдвэрлэнэ.

9.8. Энэ зүйлийн 9.5-т заасан аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын нийтлэг журмыг Засгийн газар, 9.6-д заасан сум дундын отрын бэлчээрийг ашиглах журмыг аймгийн Засаг дарга, сумын отрын бэлчээрийг ашиглах журмыг тухайн сумын Засаг дарга тус тус батална.

9.9. Ойн сан бүхий газрыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд бэлчээрт ашиглаж болно.

9.10. Улсын тусгай хамгаалалттай болон хилийн зурвас газрыг бэлчээрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага эрх бүхий дээд шатны байгууллагатай нь зөвшилцөн тодорхой хугацаанд бэлчээрийн зориулалтаар ашиглуулж болно.

9.11. Байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюулын улмаас өөр аймаг, сумын нутаг дэвсгэрт нүүдэллэх шаардлага гарвал зохих шатны Засаг дарга нар уг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ. Хэрэв тохиролцохгүйд хүрвэл уг асуудлыг дээд шатны засаг дарга, Засгийн газар шийдвэрлэнэ.

9.12. Дамжин өнгөрөх бэлчээр нь сумын Засаг даргын мэдэлд байна. Улсын чанартай мал тууврын дамжин өнгөрөх бэлчээрийг ашиглах журмыг Засгийн газар, орон нутгийн чанартай мал тууврын дамжин өнгөрөх бэлчээрийг ашиглах журмыг тухайн аймгийн Засаг дарга тус тус батална.

9.13. Баг хорооны Иргэдийн Нийтийн Хурлын саналыг харгалзан Сум, дүүргийн Засаг дарга хадлан авах бололцоотой газрыг иргэн, хуулийн этгээдэд ашиглуулахаар хуваарилж, хэрэгжилтийг зохион байгуулна.

9.14. Газрын нэгдмэл сангийн ангилалд бүртгэгдсэн хадлангийн газарт тавдугаар сарын 15-ны өдрөөс эхлэн хадлан авч дуустал мал бэлчээхийг хориглоно.

9.15. Хадлангийн талбайг усалгаатай болгох, хамгаалах, бордох, ойн зурвас тарих зэргээр өөрийн хүч хөрөнгөөр сайжруулалт хийж, ургацыг нь тогтвортой дээшлүүлэх санаачлага гарган төсөл хөтөлбөр боловсруулсан Монгол Улсын иргэн, хуулийн этгээдэд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийг үндэслэн сумын Засаг дарга гэрээгээр эзэмшүүлж болно.

## **10 дугаар зүйл. Бэлчээрийг эзэмших тухай хүсэлт гаргах**

10.1. Энэ хуулийн 9.3-т заасан эрх бүхий этгээдүүд бэлчээр эзэмших тухай хүсэлтээ сум, дүүргийн Засаг даргад гаргана.

10.2. Бэлчээр эзэмших тухай хүсэлтэд дараахь зүйлийг тусгана:

10.2.1. Эзэмших бэлчээрийн байршил, хэмжээ;

10.2.2. Малчдын бүлгийн нэр, гэрчилгээ, малын төрөл, тоо, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч нь иргэний үнэмлэх, хуулийн этгээдийн гэрчилгээ, малын тоо, төрөл;

10.2.3. Бэлчээрийг ашиглах төлөвлөгөө;

## **11 дүгээр зүйл. Бэлчээр эзэмшүүлэх гэрээ байгуулах**

11.1. Бэлчээр эзэмшүүлэх тухай шийдвэрийг үндэслэн сум, дүүргийн газрын асуудал эрхэлсэн алба, газрын даамал гэрээ байгуулж, бэлчээр эзэмших эрхийн гэрчилгээ олгоно.

11.2. Энэ хуулийн 11.1-т заасан гэрээнд дараахь зүйлийг тусгана:

11.2.1. Бэлчээр эзэмшүүлэх үндэслэл,

11.2.2. Эзэмших бэлчээрийн зориулалт,

11.2.3. Бэлчээрийн хэмжээ, байршил, хилийг харуулсан зураг,

11.2.4. Бэлчээрийн төлөв байдал, чанарын үзүүлэлт,

11.2.5. Бэлчээр эзэмшүүлэх хугацаа,

11.2.6. Бэлчээрийн төлбөр,

11.2.7. Талуудын эрх, үүрэг, хүлээх хариуцлага,

11.2.8. Шаардлагатай бусад зүйл.

11.3. Бэлчээр эзэмшигч нь бэлчээрийн төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг Газрын тухай хуулийн 58 дугаар зүйлд заасны дагуу хийлгүүлнэ. Бэлчээрийн төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа нь бэлчээр эзэмшүүлэх гэрээний салшгүй хэсэг байна.

11.4. Бэлчээр эзэмшигч нь эхний жилийн бэлчээрийн төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийлгэснээс хойш 5 жил тутамд нэг удаа хийлгэнэ.

11.5. Эрх бүхий мэргэжлийн байгууллагын хийсэн бэлчээрийн төлөв байдал, чанарын улсын хянан баталгаагаар эзэмшлийн бэлчээрийн чанарыг илт доройтуулсан нь тогтоогдвол гэрээ цуцлах үндэслэл болно.

## **12 дугаар зүйл. Бэлчээр ашиглагч, эзэмшигчийн эрх, үүрэг**

### **12.1. Бэлчээр ашиглагчийн эрх:**

12.1.1. Бэлчээрийг улирлаар ээлжлэн ашиглах бололцоогоор хангагдах;

12.1.2. Гэрээнд заасан болзол, нөхцөлийн дагуу бэлчээрийн нэгж талбарыг ашиглах;

### **12.2. Бэлчээр ашиглагчийн үүрэг.**

12.2.1. Малынхаа тоог бэлчээрийн даац, багтаамжаас хэтрүүлэхгүй байх;

12.2.2. Бусдын хөрөнгөөр барьж байгуулсан өвөлжөө хаваржааны орчимд мал бэлчээхгүй байх;

12.2.3. Нийтийн ашиглалтад байгаа уст цэг, хужир мараа бүхий газрыг бохирдуулахгүй, гамтай ашиглах;

12.2.4. Өвлийн улиралд адууг бог малын бэлчээрээс алсад гарган оторлох;

12.2.5 Доройтсон бэлчээрийг нөхөн сэргээх, ээлж сэлгээтэй болгох талаар төрөөс хэрэгжүүлж байгаа арга хэмжээнд идэвхтэй оролцож хувь нэмэр оруулах;

12.2.6. Нийтээр ашиглах бэлчээрийг нөхөн сэргээх, сайжруулах, худаг гаргах, уст цэг бий болгож ашиглах, хамгаалах асуудлыг бэлчээр зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгасны дагуу орон нутгийн удирдлагаас зохион байгуулж буй ажилд идэвхтэй оролцох.

### **12.3. Бэлчээр эзэмшигчийн эрх.**

12.3.1 Гэрээнд заасан болзол, нөхцөлийн дагуу бэлчээрийн нэгж талбарыг ашиглах;

12.3.2. Эзэмшлийн бэлчээрээ зааглах, тэмдэг тавих, бусдын мал оруулахгүй байх арга хэмжээ авах;

12.3.3. Малчдын бүлэг эзэмшиж буй бэлчээрийн хэсгийг бүлгийн бүх гишүүдийн дийлэнх олонхийн саналаар бусдад түр хугацаагаар гэрээгээр ашиглуулах;

12.3.4. Газрын тухай хуулийн 45.1-т заасан бусад эрх.

### **12.4. Бэлчээр эзэмшигчийн үүрэг:**

12.4.1. Бэлчээр сайжруулах, ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөөтэй байх;

12.4.2. Бэлчээрийн төлөв байдлыг доройтуулахгүй байх;

12.4.3. Бэлчээрийн мал аж ахуй эрхлэгч нь бэлчээр эзэмших тохиолдолд малчдын бүлэгт элсэх;

12.4.4. Малынхаа тоог бэлчээрийн даац, багтаамжаас хэтрүүлэхгүй байх;

12.4.5. Эзэмшилд байгаа бэлчээрийг сайжруулах, усжуулах, уст цэг бий болгох, хамгаалах;

12.4.5. Эзэмшлийн бэлчээрт хөнөөлт мэрэгч амьтан, шавьж тархсан тохиолдолд байгаль орчинд халгүй аргаар тэмцэх бүх талын арга хэмжээ авч, сум, дүүргийн Засаг даргад мэдэгдэх;

12.4.6. Бэлчээр эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх харилцааг Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу шийдвэрлэнэ.

12.4.7. Газрын тухай хуулийн 50 дугаар зүйлд заасан бусад үүрэг.

### **13 дугаар зүйл. Бэлчээрийн газрын төлбөр**

13.1. Бэлчээрийн газрын төлбөртэй холбогдсон харилцааг Газрын төлбөрийн тухай хуулиар зохицуулна.

### **14 дүгээр зүйл. Бэлчээрийг ашиглах, эзэмшихэд хориглох зүйл**

14.1. Бэлчээрийн төлөв байдал, чанарыг доройтуулахгүйн тулд бэлчээрийг ашиглахад дараахь зүйлийг хориглоно:

14.1.1. Бэлчээр эзэмших эрхийн гэрчилгээг барьцаалах, худалдах, бэлэглэх;

14.1.2. Цөл, цөлөрхөг хээрийн бүсийн болон хөрсний эвдрэл, цөлжилт үүсэх нөхцөл бүрдсэн бэлчээрийн ургамлыг түүх, хадах;

14.1.3. Эрх бүхий этгээдийн зөвшөөрөлгүйгээр бэлчээрт авто зам гаргах, бэлчээрийн хөрсийг эвдэх, ашигт малтмалын хайгуул хийх, олборлох, бохирдуулах;

14.1.4. Бэлчээрийн даацаас хэтэрсэн тооны мал бэлчээх;

14.1.5. Бусдын эзэмшил, ашиглалтын бэлчээрт зөвшөөрөлгүйгээр мал оруулах бэлчээх;

14.1.6. Эрчимжсэн мал аж ахуй эрхлэх бүс нутагт бэлчээрийн мал аж ахуй эрхлэх.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ**

### **15 дугаар зүйл. Бэлчээртэй холбогдсон маргааныг шийдвэрлэх**

15.1. Бэлчээрийг эзэмших, ашиглахтай холбогдон эзэмшигч, ашиглагч нарын хооронд гарсан аливаа маргааныг маргалдагч талууд хоорондоо харилцан тохиролцон шийдвэрлэх бөгөөд эс тохиролцвол энэ хуулийн 15.2-т зааснаар шийдвэрлүүлнэ.

15.2. Тухайн орон нутагт бэлчээрийг эзэмших, ашиглах явцад гарсан аливаа маргааныг баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцэж зохицуулна. Эс тохиролцвол дээд шатны Иргэдийн хурал шийдвэрлэнэ.

15.3. Бэлчээрийг эзэмших, ашиглах асуудлаар засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж хоорондын маргааныг тухайн шатны Засаг дарга нар хууль тогтоомжийн хүрээнд тохиролцон шийдвэрлэнэ. Эс тохиролцвол дээд шатны Засаг дарга буюу Засгийн газар шийдвэрлэнэ.

15.4. Энэ хуулийн 15.1, 15.2, 15.3-т зааснаар маргаан шийдвэрлэгдээгүй бол шүүхээр шийдвэрлэнэ.

## **16 дугаар зүйл. Бэлчээрийн тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

16.1. Бэлчээрийн тухай хууль тогтоомж зөрчсөн гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол байгаль орчны улсын хяналтын байцаагч дор дурдсан захиргааны шийтгэл оногдуулна:

16.1.2. бусдын эзэмшлийн бэлчээрт мал оруулсан бол буруутай этгээдээр хохирлыг нөхөн төлүүлж, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёроос тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

16.1.3. аймаг дундын болон сум дундын отрын бэлчээрт зөвшөөрөлгүйгээр малаа оруулсан, отрын бэлчээр ашиглах горим зөрчсөн бол буруутай этгээдээр хохирлыг нөхөн төлүүлж, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурваас зургаа дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

16.1.4. энэ хуульд заасан бэлчээр зохион байгуулалтын төлөвлөгөө, журмыг зөрчсөн иргэнийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёроос тав, аж ахуйн нэгж, байгууллагыг таваас арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

16.1.5. энэ хуулийн 9.1, 12.2 дахь заалт, 14 дүгээр зүйлийг зөрчсөн бол бол учирсан хохирлыг нөхөн төлүүлж, иргэнийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурваас зургаа, аж ахуйн нэгж, байгууллагыг арваас арван тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

16.1.6. энэ хуулийн 12.2.1, 12.2.3, 12.4.2, 12.4.4, дэх заалтыг зөрчсөн бол иргэнийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёроос дөрөв, аж ахуйн нэгж, байгууллагыг таваас арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

16.1.7. гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй бэлчээр эзэмшигчийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурваас найм дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

16.1.8. энэ хуулийн 15 дугаар зүйлд заасан хориглосон үйл ажиллагаа явуулсан бэлчээр эзэмшигч, ашиглагчийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох.

### **17 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох**

17.1. Энэ хуулийг ... оны ... дүгээр сарын ... -ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

## **ГАРЫН ҮСЭГ**

Төсөл

## **МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

**2010...оны...дугаар**

**Улаанбаатар**

**сарын ... ны ... өдөр**

**хот**

## **ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ**

### **ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Газрын тухай хуулийн 4, 6, 28, 44 дүгээр зүйлд дор дурьдсан агуулгатай хэсэг, заалт нэмсүгэй:

1/ 4.1.6. газар зохион байгуулалтын үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах;

2/ 6.1.1. бэлчээрийн харилцааг **тусгай** хуулиар зохицуулна;

3/ 28.1.4. эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид, малчдын бүлэг, нөхөрлөл дундаа хамтран эзэмшихэд зориулсан бэлчээрийн;

**2 дугаар зүйл.** Газрын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.16, 6 дугаар зүйлийн 6.2.1.дэхь хэсгийг дор дурьдснаар өөрчлөн найруулсугай.

1/ 3.1.6. “бэлчээр” гэж мал, амьтан идээшлэх **боломжтой** ургамлын нөмрөг бүхий газрыг;

2/ 6.2.1. **эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид**, малчдын бүлэг, нөхөрлөлд дундаа хамтран ашиглахад зориулан гэрээгээр эзэмшүүлснээс бусад бэлчээр, хадлан, бэлчээр дэхь уст цэг, хужир, мараа бүхий газар;

**3 дугаар зүйл.** Газрын тухай хуулийн 52 дугаар зүйлийг хүчингүй болсонд тооцсугай:

**4 дүгээр зүйл.** Энэ хуулийг батлагдсан өдрөөс буюу 2010.... оны ... дугаар сарын ... ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.